



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 01 дүгээр сарын 24 өдөр Дугаар 09

Хэрлэн сум

IX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 09 дүгээр хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 18:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 86,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Улаанбаатар хотоос иргэдийг татан авч гэрийн тусгаарлалтад шилжүүлэхэд тулгамдсан асуудал, цаашид авч хэрэгжүүлэх ажлуудын талаар мэдээлэл сонсох,  
*Багуудын ажлын хэсэг*

2. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцох хүн хүчний нөөцийн асуудлын талаар хэлэлцэх,  
*АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,



Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,

АЗДТГ-ын Олон нийттэй харилцах албаны дарга, Онцгой комиссын  
гишүүн Э.Батболд нарт:

1.1. Тусгаарлалтын журам зөрчсөн иргэнийг Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газрын бүрэлдэхүүнтэй ажиллагааны багийг томилж хавьтал болсон иргэнийг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасагт тусгаарлаж зөрчлийн тухай олон нийтэд мэдээллэж сэрэмжлүүлэхийг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

1.2. Халхгол сумын харьяат иргэн А.Батжаргал нь сумаас ирж авах унаа байхгүй, суманд өөрийгөө тусгаарлах байргүй, зорилтот бүлэгт хамааралтай учир 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр автобусаар ирэхэд нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасагт тусгаарлах, гарах зардлыг аймгийн Онцгой комиссоос шийдвэрлэхийг,

/  / М.Бадамсүрэн  
/  / Э.Ганжигүүр

1.3.Хөлөнбуйр сумын хяналтын цэгт Улаанбаатар хотоос Дорнод аймгийн иргэдийг тээвэрлэж буй автобусны ачааны хэсгийг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулахыг, халдваргүйжүүлэлтийн ажилд хяналт тавихыг Мэргэжлийн хяналтын газарт,

1.4.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн харъяалалтай иргэдийг татан авах бүртгэл судалгаа, нэрсийг гаргахыг,

1.5.Өрхийн эмч нарт татан авалтаар ирсэн иргэдэд хяналт тавьж ажиллах тухай албан бичгээр чиглэл өгөхийг,

1.6.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн харъяалалтай иргэдийн татан авалт хийх бүртгэлийг зогсоосон тухай иргэд олон нийтэд мэдээллэхийг,

1.7.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн харъяалалтай иргэдийн бүртгэл, мэдээллийг баг хариуцсан ажлын хэсгүүдэд 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11:00 цагт багтааж хүргүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Улсын бүртгэлийн хэлстийн дарга Д.Оюунбаяр нарт:

1.8.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн харъяалалтай иргэдийг татан авах бүртгэлд хяналт тавьж ажиллахыг,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

1.9.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн харъяалалтай иргэдийг татан авалт хийсэн автобусын жолооч нар тухайн компанийн түрээсийн байр тусгаарлах байрны шаардлага хангаагүй тохиолдолд буудалд тусгаарлаж гарсан зардлыг тухайн жолоочоор төлүүлж зохион байгуулахыг,

1.10.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн харъяалалтай иргэдийг татан авах автобусанд иргэдээс ахлагч томилж шаардлагатай тохиолдолд мэдээлэл авч ажиллахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын орлогч дарга, цагдаагийн дэд хурандаа З.Баянжаргал нарт:

1.11.Автобусны жолооч нарын тусгаарлалтад хяналт тавьж ажиллахыг ,

Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

1.12.Улаанбаатар хотоос Дорнод аймгийн харъяалалтай иргэдийг татан авах ажилд итгэмжлэлгүй хүүхэд зорчуулахгүй байх,

Цагдаагийн газрын орлогч дарга, цагдаагийн дэд хурандаа З.Баянжаргал-д:

1.13.Хөлөнбуйр сумын хяналтын цэгээс иргэд тээвэрлэсэн автобусыг Чойбалсан хотод иргэнийг буулгахад Цагдаагийн автомашин хамгаалалтад явахыг,

/  / М.Бадамсүрэн  
/  / Э.Ганжигүүр

Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

1.14. Иргэдийн татан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахад гарах автомашины шатахууны зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Хоёр. АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х. Бат-Эрдэнэ-д:

2.1. Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцох хүн хүчний нөөцийн судалгааг Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлэхийг,

2.2. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт 09:00-17:00 цагт хүртэлх хугацаанд үүрэг гүйцэтгэх төрийн албан хаагч ажиллах хуваарийг боловсруулж батлуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН АХМАД Э.ГАНЖИГҮҮР